



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 9/337

Мандалговь

Г Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг
зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, "Эрүүл мэндийн тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улс орны хэмжээнд Ковид-19 халдварт өвчин тархаж болзошгүй нөхцөл үүсээд байгаатай холбогдуулан аймгийн төвд хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахыг аймгийн Зоонозын өвчин судлалын төв (Б.Алтантөгс), ахуйн шавьж, мэрэгч, устгал халдваргүйжүүлэлтийн "Наран булаг" ХХК (М.Алтанцог)-д үүрэг болгосугай.

Хоёр. Нутаг дэвсгэртээ хүнсний худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн ажлыг орон нутгийн нөөц, мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010921